



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/827

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.7, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа гэрч, хохирогч насанд хүрээгүй хүний эрх ашгийг хамгаалах, хүүхэд оролцсон, хохирсон гэмт хэрэг, зөрчлийн насанд хүрээгүй хүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, хүүхдийн нэр төр, хувийн орон зайг хангах үүднээс баруун 5 сумыг харъяалан гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа явуулдаг Булган суман дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний орчин нөхцлийг сайжруулж тохижуулсугай.

2. Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний тохижилтонд шаардагдах 3943800 төгрөг /гурван сая есөн зуун дөчин гурван мянга найман зуун/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн Гэр бүлийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн зардлаас тооцож гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Тус өрөөг тохижуулж хүүхдэд зориулсан үйл ажиллагаа явуулж зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга /Ц.Номинчимэг/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Н.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/827 Ch
02 4221